



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/121/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Алтанзул Утас: 70523020 Цахим хаяг: altanzulb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.24 № 16/143

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
Ж.НАРАНБОЛД ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР _____ Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	46.1	50.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	274.8	226.5
Нийт хөрөнгийн дүн	320.9	276.8
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	320.9	276.8
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	320.9	276.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	485.2	315.4
Үйл ажиллагааны зардлын дүн	459.0	359.5
Үйл ажиллагааны үр дүн	26.2	-44.1
Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
Үйл ажиллагааны нийт үр дүн	26.2	-44.1
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	413.5	313.0
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	411.8	314.3
Үйл ажиллагааны ЦМГ	1.7	-1.3
Хөрөнгө оруулалтын ЦМГ	-1.1	-
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	0.6	-1.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4.2	4.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4.8	3.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	294.7	320.9
Тайлант оны үр дүн	26.2	-44.1
Эцсийн үлдэгдэл	320.9	276.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	397.1	292.0
Урсгал зардал	397.1	292.0
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	397.1	287.7
Улсын төсвөөс санхүүжих	390.1	287.7
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7.0	-

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын эрхэм зорилго:

Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хөгжүүлэн, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэн экспортын баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хүн амыг эрүүл, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Дорноговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд харьяалах нутаг дэвсгэр дэх хүнс, газар тариалан, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хоршоо, бирж, эктейншныг хөгжүүлэх бодлого, зорилт, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн түвшинд хангах, зохицуулах, удирдан зохион байгуулах, аймгийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төсөл, төсвийн төсөөлөлд хариуцсан чиглэлээр санал боловсруулах, тухай жилийн батлагдсан төсвийн багцад тусгагдсан төсвийг үр оновчтой зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, хүнс, газар тариалан, хөнгөн болон жижиг, дунд үйлдвэр, хоршоо, бирж, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийг мэргэжил, арга зүйгээр болон нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээгээр хангах, төрийн шуурхай үйлчилгээг үзүүлэх

Гурав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээллийг үнэн зөв, заасан хугацаанд оруулсан байна.

Дөрөв. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Тав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 1 алдааг залруулж, 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Нийгмийн даатгалын шимтгэлийн урд оны авлагыг санхүүгийн байдлын тайланд тусгаагүй байсан алдааг залруулав.

Албан шаардлага

1. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 0.6 сая төгрөгийг даатгалын хураамжийн зардалд зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай”-ын “2108-Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж. Тус бүлгийн зардлуудыг эдийн засгийн ангилал тус бүрээр хянана” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 1.1 Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 77.8 сая төгрөгийн 130 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.
- 2.1 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, эсхүл дахин шинээр үнэ тогтоож, ашиглалтын байдлыг тодорхой болгох

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
НИЙТ									

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	0.6	1	0	0	0	1	0.6	1	0
НИЙТ		3	0.6	1	0	0	0	1	0.6	1	0